



**БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ**

2018 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 44.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга хот байгуулалтын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2018 оны 11 дүгээр тушаалаар “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих журам” батлагдаж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3841 дугаарт бүртгүүлсэнтэй холбогдуулан тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлагыг Барилга, хот байгуулалтын сайдын “Журам батлах тухай” 2013 оны 89 дүгээр тушаалаар батлагдсан ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлагатай дүйцүүлсэн аргачлалыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуй нэгжийн жагсаалтыг 2015, 2016, 2017, 2018 онуудаар дээрх аргачлалтай уялдуулан дэлгэрэнгүй гаргаж, нийтэд мэдээлэхийг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Соёмбо/, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын ерөнхийлөгч /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.

3. Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон шинэчилсэн журам батлагдан гарахаас өмнө олгогдсон барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг тухайн гэрчилгээнд заасан хугацаанд хүчинтэй байхаар тооцсугай.

4. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдүүд захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг хуульд заасны дагуу албан ёсоор мэдэгдэх, сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.



Х.БАДЕЛХАН

Барилга хот байгуулалтын сайдын
2018 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн
33 дугаар тушаалын хавсралт



НЭГ. ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

БХБ-ын сайдын 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 89 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага	БХБ-ын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага
Ажлын төрөл	Ажлын төрөл
1	2
1.1.1. Бүс нутгийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа	ЗТ-9.1 Бүс нутгийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа
1.1.2. Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа	ЗТ-9.2 Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа
1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)	ЗТ-2.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) ЗТ-3.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) ЗТ-8.1 Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл
1.2.2. 1-16 давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, Барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) Барилга байгууламжийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламж (резервуар, бункер, силос, цамхаг, яндан, антенна гэх мэт)-ийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)	ЗТ-4.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) ЗТ-8.1 Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл
1.2.3. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)	ЗТ-4.10 Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)
1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн	ЗТ-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

<p>зураг төсөл</p>	<p>ЗТ-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-6.5 Хөргөх байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-7.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-7.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-7.5 Хөргөх байгууламжийн зураг төсөл</p>
<p>1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл) Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл</p>	<p>ЗТ-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл ЗТ-6.4 Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл ЗТ-7.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл ЗТ-7.4 Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл</p>
<p>1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв</p>	<p>ЗТ-11.1 Барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, төсөв ЗТ-11.2 Барилга байгууламжийн ажлын төсөв ЗТ-11.3 Барилга байгууламжийн засварын ажлын төсөв</p>

<p>1.2.7. Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 51-150 м хүртэл өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 17-35 давхар хүртэл барилгын зураг төсөл, онцгой төвөгшилтэй бүтээц (БЗБТ, АГТ, ҮЗБТ)</p>	<p>ЗТ-5.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) ЗТ-8.1 Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл</p>
<p>1.3.1. Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг</p>	<p>ЗТ-3.5 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг ЗТ-4.5 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг ЗТ-5.5 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг</p>
<p>1.3.2. Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг</p>	<p>ЗТ-3.4 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг ЗТ-4.4 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг ЗТ-5.4 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг</p>
<p>1.3.3. Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /35 кВ хүртэл/</p>	<p>ЗТ-3.6 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг</p>
<p>1.3.4. Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /220 кВ хүртэл/</p>	<p>ЗТ-4.6 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг ЗТ-5.6 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг</p>
<p>1.3.5. Усны барилга байгууламжийн зураг төсөл</p>	<p>ЗТ-2.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл ЗТ-3.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл ЗТ-4.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл ЗТ-5.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл</p>
<p>1.3.6. Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл</p>	<p>ЗТ-3.8 Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл ЗТ-4.8 Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл ЗТ-5.8 Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл</p>

<p>1.4.1. Бүс нутаг, хот суурингийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөөнд зориулан явуулах инженер геологийн дунд, том масштабын зураглал, инженер-гидрогеологи, инженер-геологи, инженер геозкологийн суурь судалгаа.</p>	<p>ЗТ-10.1 Бүс нутаг, хот суурингийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөөнд зориулан явуулах инженер геологийн дунд, том масштабын зураглал, инженер-гидрогеологи, инженер-геологи, инженер геозкологийн суурь судалгаа.</p>
<p>1.4.2. Инженер-геологийн хүнд нөхцөлтэй талбай, нутаг дэвсгэрт төлөвлөх бүх төрлийн барилга байгууламжууд, 10 ба түүнээс дээш давхар иргэний болон үйлдвэрийн барилга, уул уурхай, цахилгаан станцын цогцолбор байгууламжууд, усан сан, гидротехникийн байгууламж, олон улсын болон 1-р ангиллын авто зам, нисэх зурвас, төмөр зам, өндөр даацын төмөр бетон гүүр, газар доогуурх барилга байгууламжид зориулсан инженер-геологийн судалгаа</p>	<p>ЗТ-10.2 Инженер-геологийн хүнд нөхцөлтэй талбай, нутаг дэвсгэрт төлөвлөх бүх төрлийн барилга байгууламжууд, 10 ба түүнээс дээш давхар иргэний болон үйлдвэрийн барилга, уул уурхай, цахилгаан станцын цогцолбор байгууламжууд, усан сан, гидротехникийн байгууламж, олон улсын болон 1-р ангиллын авто зам, нисэх зурвас, төмөр зам, өндөр даацын төмөр бетон гүүр, газар доогуурх барилга байгууламжид зориулсан инженер-геологийн судалгаа</p>
<p>1.5.1. Технологийн зураг төсөл /эрчим хүчний байгууламж, хөнгөн ба хүнд үйлдвэр, уул уурхайн технологи/</p>	<p>ЗТ-2.3 Үйлдвэр болон агуулахын барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-3.3 Үйлдвэр болон агуулахын барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-4.3 Үйлдвэр болон агуулахын барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-5.3 Үйлдвэр болон агуулахын барилга байгууламжийн технологийн зураг төсөл</p>
	<p>ЗТ-3.7 Газрын тосны барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-4.7 Газрын тосны барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЗТ-5.7 Газрын тосны барилга байгууламжийн технологийн зураг төсөл</p>
	<p>ЗТ-4.9 Газар доорхи гарц тусгай зориулалтын барилга байгууламжийн зураг төсөл</p>
	<p>ЗТ-12.1 Барилга байгууламжийн паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах</p>
	<p>ЗТ-13.1 Машин, тоног төхөөрөмж, түүнийн эд ангийн үйлдвэрлэлийн зураг төсөл</p>

ХОЁР. БАРИЛГЫН УГСРАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

<p>БХБ-ын сайдын 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 89 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага</p>	<p>БХБ-ын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага</p>
<p>Ажлын төрөл</p>	<p>Ажлын төрөл</p>
<p>1</p>	<p>2</p>

<p>2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт</p>	<p>БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил</p>
<p>2.1.1.* Барилгын засал чимэглэл, интерьерийн ажил</p>	
<p>2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (1- 5 давхар хүртэл)</p>	<p>БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p>
<p>2.1.3. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил (1-9 давхар хүртэл) Ган бүтээцэн барилгын ажил (фермийн алгасал нь 18 м, баганын өндөр нь 6 м хүртэл)</p>	<p>БА-3.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p>
<p>2.1.4. Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн, барилгын ажил (1-16 давхар хүртэл), Цамхаг, тулгуур, түшиц хана, яндан антенна зэрэг 30 м хүртэл өндөр угсармал ба цутгамал бетон, төмөр бетон, ган бүтээцтэй байгууламжийн ажил</p>	<p>БА-4.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p>
<p>2.1.5. Газар доорхи гарц тусгай зориулалтын угсармал ба цутгамал төмөр бетон болон ган бүтээцтэй, барилга байгууламжийн ажил</p>	<p>БА-4.7 Газар доорхи гарц тусгай зориулалтын барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил БА-5.7 Газар доорхи гарц тусгай зориулалтын, бусад барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p>
<p>2.1.6. 17-35 давхар хүртэл өндөр барилгын угсармал ба цутгамал төмөр бетон бүтээц, мөн ган бүтээцтэй угсралтын ажил Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 31 м-ээс дээш өндөр байгууламж, 60 м-ээс дээш алгасалтай барилга байгууламж</p>	<p>БА-5.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p>
<p>2.1.7. Тухайлсан объект буюу 35-аас дээш давхар өндөр барилга байгууламжийн барилгын ажил</p>	
<p>2.1.8. Түүх, соёлын барилга угсралтын ажил</p>	<p>БА-4.8 Түүх,соёлын барилга байгууламжийн сэргээн засварлалт, угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p>

<p>2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт</p>	<p>БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт БА-6.2 Барилгын Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт БА-7.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт БА-7.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт</p>
<p>2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт</p>	<p>БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт БА-7.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт БА-7.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт</p>
<p>2.2.3. Ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт</p>	<p>БА-3.3 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт БА-4.3 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт БА-5.3 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт</p>
<p>2.2.4. Дулааны болон усан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт</p>	<p>БА-3.4 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт БА-4.4 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт БА-5.4 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт</p>

2.2.5. Нефтийн агуулах, шатахуун түгээх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн угсралт	БА-3.6 Газрын тосны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил БА-4.6 Газрын тосны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил БА-5.6 Газрын тосны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
2.2.6. Хийн хангамжийн байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн угсралт	
2.2.7. Хөргөх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн угсралт	БА-6.5 Хөргөх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн угсралт БА-7.5 Хөргөх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн угсралт
2.2.8. Цахилгаан эрчим хүч дамжуулах гол /магистраль/ шугам /35 кВ хүртэл/ угсралт	БА-3.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт
2.3.1. Услалтын уст цэг, худаг, Услалтын системийн гидротехникийн барилга байгууламжийн ажил	БА-2.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
2.3.2. Хөрсний ус доошлуулах, шүүрүүлэх, эргийн бэхэлгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан, хоолой болон газар шорооны тусгай ажил	БА-3.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
2.3.3. Усан цахилгаан станцын барилга байгууламжийн ажил	БА-4.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил БА-5.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
	БА-4.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт БА-5.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт

ГУРАВ. БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

БХБ-ын сайдын 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 89 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага	БХБ-ын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага
Үйлдвэрлэлийн чиглэл	Үйлдвэрлэлийн чиглэл
1	2
3.1.1. Технологийн иж бүрэн дамжлага бүхий цементийн үйлдвэр	МУ-1.1. Технологийн иж бүрэн дамжлага бүхий цементийн үйлдвэр
3.1.2. Чулуунцар тээрэмдэх шугам бүхий цементийн үйлдвэр	МУ-1.2. Чулуунцар тээрэмдэх шугам бүхий цементийн үйлдвэр
3.1.3 Цемент ,Шохой, магни ,гөлтгөнө болон холимог барьцалдуулагч бүхий материалын үйлдвэр	МУ-1.3 Цемент ,Шохой, магни ,гөлтгөнө болон холимог барьцалдуулагч бүхий материалын үйлдвэр

3.2.1. Дүүргэгч материал элс, хайрга, дайрга ,галт уулын гаралтай чулуу бутлан ангилах , байгалийн чулуу олборлох, боловсруулах үйлдвэр	МҮ-2.1. Дүүргэгч материал элс, хайрга, дайрга ,галт уулын гаралтай чулуу бутлан ангилах , байгалийн чулуу олборлох, боловсруулах үйлдвэр
3.3 .1. Эрдэс /чулуун/ хөвөн материалын үйлдвэр	МҮ-3 .1. Эрдэс /чулуун/ хөвөн материалын үйлдвэр
3.3.2 Хөнгөн ба сүвэрхэг дүүргэгч материалын үйлдвэр	МҮ-3.2 Хөнгөн ба сүвэрхэг дүүргэгч материалын үйлдвэр
3.3.3. Хөөсөн полистрол хавтан, эдлэлийн үйлдвэр / EPS EPP,EPE,Neopor, XPS, XPE, PUR төрлийн дуу, дулаан тусгаарлах материалын үйлдвэр	МҮ-3.3. Хөөсөн полистрол хавтан, эдлэлийн үйлдвэр / EPS EPP,EPE,Neopor, XPS, XPE, PUR төрлийн дуу, дулаан тусгаарлах материалын үйлдвэр
3.3.4. Полиуретан /PUR/ шүршдэг болон цутгадаг хөөс, скорлуп , гулдмай хавтан, авдаггүй хэв ,бусад эдлэлийн үйлдвэр	МҮ-3.4. Полиуретан /PUR/ шүршдэг болон цутгадаг хөөс, скорлуп , гулдмай хавтан, авдаггүй хэв ,бусад эдлэлийн үйлдвэр
3.3.5. Сендвич хавтангийн үйлдвэр	МҮ-3.5. Сендвич хавтангийн үйлдвэр
3.3.6. Шохой, цемент, гөлтгөнө болон холимог холбогчтой хөнгөн бетон гулдмай, хавтангийн үйлдвэр	МҮ-3.6. Шохой, цемент, гөлтгөнө болон холимог холбогчтой хөнгөн бетон гулдмай, хавтангийн үйлдвэр
3.3.7. Байгалийн болон зохиомол хөнгөн дүүргэгч бүхий дуу, дулаан тусгаарлагч гулдмай, хавтгаалжийн үйлдвэр	МҮ-3.7. Байгалийн болон зохиомол хөнгөн дүүргэгч бүхий дуу, дулаан тусгаарлагч гулдмай, хавтгаалжийн үйлдвэр
3.4.1. Бетон зуурмагийн үйлдвэр бүхий төмөр бетон эдлэлийн үйлдвэр	МҮ-4.1. Бетон зуурмагийн үйлдвэр бүхий төмөр бетон эдлэлийн үйлдвэр
3.4.2. Бетон зуурмагийн үйлдвэр	МҮ-4.2. Бетон зуурмагийн үйлдвэр
3.5.1 Ган туйван, бетон бүтээцийн мяндас полимер арматур , катангийн үйлдвэр	МҮ-5.1 Ган туйван, бетон бүтээцийн мяндас полимер арматур , катангийн үйлдвэр
3.5.2 Ган бөмбөлөг, цылпепс бусад хийцийн үйлдвэр	МҮ-5.2 Ган бөмбөлөг, цылпепс бусад хийцийн үйлдвэр
3.5.3 Даацын металл хийц эдлэл, бүтээцийн үйлдвэр	МҮ-5.3 Даацын металл хийц эдлэл, бүтээцийн үйлдвэр
3.6.1 Барилгын сантехникийн бүх төрлийн хуванцар хоолой , холбох,хэрэгслэлийн үйлдвэр	МҮ-6.1 Барилгын сантехникийн бүх төрлийн хуванцар хоолой , холбох,хэрэгслэлийн үйлдвэр
3.7.1 Бетоны химийн болон идэвхит эрдэс нэмэлтийн үйлдвэр	МҮ-7.1 Бетоны химийн болон идэвхит эрдэс нэмэлтийн үйлдвэр
3.7.2 Бусад химийн гаралтэй барилгын материалын үйлдвэр	МҮ-7.2 Бусад химийн гаралтэй барилгын материалын үйлдвэр
3.8.1. Керамик тоосго, гулдмайн үйлдвэр	МҮ-8.1. Керамик тоосго, гулдмайн үйлдвэр
3.8.2 Дээврийн вааран керамик хавтанцарын үйлдвэр	МҮ-8.2 Дээврийн вааран керамик хавтанцарын үйлдвэр
3.8.3 Галд тэсвэртэй керамик эдлэлийн үйлдвэр	МҮ-8.3 Галд тэсвэртэй керамик эдлэлийн үйлдвэр

3.9.1 Дээврийн хуйлмал, зүймэл /металл, металл бус Нано технологийн, / материалын үйлдвэр	МҮ-9.1 Дээврийн хуйлмал, зүймэл /металл, металл бус Нано технологийн, / материалын үйлдвэр
3.10.1 Шалны бүх төрлийн материалын үйлдвэр	МҮ-10.1 Шалны бүх төрлийн материалын үйлдвэр

**ДӨРӨВ. ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,
УГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

БХБ-ын сайдын 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 89 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага	БХБ-ын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага
Ажлын төрөл	Ажлын төрөл
1	2
4.1. Лифт, эскалатор, зорчигчийн ган татлагат болон чирэх замын угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ	ӨБ-4.1 Лифт, эскалатор, зорчигчийн ган татлагат болон чирэх замын угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ ӨБ-5.1 Лифт, эскалатор, зорчигчийн ган татлагат болон чирэх замын угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ
4.2 Ачаа өргөх кран, төрөл бүрийн өргүүрийн (Барилгын өргүүр, манипуляторт кран, сагстай өргөгч) угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ	ӨБ-4.2 Ачаа өргөх кран, төрөл бүрийн өргүүрийн (Барилгын өргүүр, манипуляторт кран, сагстай өргөгч) угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ ӨБ-5.2 Ачаа өргөх кран, төрөл бүрийн өргүүрийн (Барилгын өргүүр, манипуляторт кран, сагстай өргөгч) угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ
4.3 Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл	ӨБ-6.1 Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл